

Илтгэлийн сэдэв:  
**Монгол улсад уул уурхайн бүтээгдэхүүний  
бирж байгуулах шаардлага, боломж**

Илгэгч: Д.Галсандорж (Доктор, проф)  
С.Тэгшжаргал (Докторант)  
Утас: 98980056  
[tegshee\\_s@yahoo.com](mailto:tegshee_s@yahoo.com)

### **Хураангуй**

*Монгол улсын эдийн засаг хурдацтай өсч байгаа нь уул уурхайн салбарын өсөлттэй салшгүй холбоотой. Уул уурхайн салбарт өсөлт бий болж байгаа эерэг үр дүнгүүд гарч байгаа ч эрдсийн бүтээгдэхүүнийг түүхий хэлбэрээр, хямд үнээр нэг зах зээл экспортлож байна. Үүний зэрэгцээ манай орны уул уурхайн бэлтгэн нийлүүлэлт эмх замбаагүй, зохион байгуулалтгүй байгаа учраас төсвийн орлого бүрдэлт, технологи, түүхий эдийн чанар, боловсруулалтын түвшин хангалтгүй байгаа нь олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг сулруулж байгаа зэрэг сөрөг үзэгдлүүд байсаар байна.*

*Монгол улсын уул уурхайн салбарт тулгарч байгаа асуудлуудыг судалж, олон улсын жишигээр уул уурхайн бүтээгдэхүүний биржийг Монгол улсад байгуулах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн талаар судлахдаа манай орны эрдсийн бүтээгдэхүүний нөөц, үйлдвэрлэл, хэрэглээ, олон улсын металлын биржийн туршилага зэргийг харгалзаж үзсэн болно.*

**Түлхүүр үг:** эрдэс бүтээгдэхүүн, уул уурхайн бирж, үнэт металл, чөлөөт үнэ

### **Оршил**

Монгол Улсын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогыг авч хэрэгжүүлсний үр дүнд манай уул уурхайн салбарт орох гадаадын шууд хөрөнгө оруулалт тогтвортой өсч байна. Стратегийн ач холбогдолтой томоохон ордууд, тухайлбал Тавантолгой ба Оюутолгой эдийн засгийн эргэлтэд орж өгөөжөө өгч байна. Гэвч манай уул уурхайн салбарын экспортын худалдаанд үнэ, чанар, боловсруулалт, худалдан авалттай холбоотой олон сөрөг үр дагаварууд, асуудлууд тулгарч байна.

Манай эрдсийн экспортын худалдаанд тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах боломж, хууль эрх зүйн орчныг бий болгох асуудлаар бодлогын судлахаар шаардлагатай болсон.

Судалгааны зорилго бол уул уурхайн бүтээгдэхүүний биржийг Монголд байгуулах боломж, ялангуяа уул уурхайн бүтээгдэхүүний нөөц, биржийн байршил, хүчин чадал, биржээр борлуулах бүтээгдэхүүний талаар судлах явдал байв.

Судалгааны ажилд БНХАУ-ын Шанхайн болон Тяньжингийн бирж, Английн Лондонгийн металлын бирж, Энэтхэгийн барааны бирж, Авсралийн биржийн үйл ажиллагааны тайлан болон дараах анхдагч болон хоёрдогч мэдээллийн эх үүсвэрүүдийг ашигласан.

- Ашигт малтмалын газар, Гаалийн Ерөнхий газар, Уул уурхайн яам, Гадаад харилцааны яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Гадаадын хөрөнгө оруулалтын газруудын мэдээ, тайлан;
- “Эрдмин” ХХК, “Эрдэнэт” ХХК, “Монголросцветмет” ХХК, “Эрдэнэс Таван толгой” ХХК, “Оюутолгой” ХХК, “МАК” ХХК болон “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” зэрэг 10 гаруй томоохон аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлийг авч тайланд тусгасан.

## Нэг. Монгол улсын уул уурхайн салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал ба бирж байгуулах шаардлага

### 1.1. Монгол улсын уул уурхайн салбарын өнөөгийн байдал:

Монгол улсын эдийн засгийн өсөлт 2011 онд 17.3 хувьд хүрсэн нь өмнөх оныхоос 2 дахин нэмэгдэж байна. Энэхүү өсөлт нь уул уурхайн салбарын өсөлттэй салшгүй холбоотой билээ.

2011 онд уул уурхай салбар нь:

- ❖ ДНБ-ний **20.3 %**,
- ❖ АҮБ-ний **69.6 %**,
- ❖ Экспортын бүтээгдэхүүний **90.0 %**,
- ❖ Төсвийн орлогын **40 %** гаруй эзэлж байна.


Энэ нь уул уурхайн салбар эдийн засагт томоохон байр суурь эзэлсэн байгааг илтгэж байна. Энэ салбарын ДНБ, АҮНБ болон экспортын орлогод эзлэх байр суурийг хүснэгт-1, 2 болон график-1, 2, 3 зэрэгт харуулав.

**Хүснэгт № 01: Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин**

Үзүүлэлт	Хэм. нэгж	2003	2005	2008	2009	2010	2011
<b>ДНБ</b>	тэрбум төг	1.480	2.780	6.556	6.591	8.415	10.830
<b>1 хүнд ногдох ДНБ</b>	мян.төг	594	1.091	2.465	2.432	3.026	3.821
<b>Уул уурхай, олборлох үйлдвэр</b>	тэрбум төг	186	461	1.324	1.286	1.913	2.191
<b>Уул уурхай, олборлох үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувь</b>	%	<b>12.6</b>	<b>16.6</b>	<b>20.2</b>	<b>19.5</b>	<b>22.7</b>	<b>20.2</b>

Эх үүсвэр: Ашигт малтмалын газар, 2012 он

**График № 01: Уул уурхайн салбарын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь**



Эх үүсвэр: Ашигт малтмалын газар, 2012 он


**Хүснэгт № 2: Уул уурхайн салбарын аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд эзлэх хувь**

Үзүүлэлт	Хэм.нэгж	2003	2005	2008	2009	2010	2011
<b>Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн</b>	тэрбум. Төг	879	1.457	3.514	3.442	4.727	5.028
<b>Уул уурхайн бүтээгдэхүүн</b>	тэрбум. Төг	436	953	1.981	2.094	3.155	3.501
<b>УУБ-ний АҮНБ-д эзлэх хувь</b>	%	49.6	65.4	56.4	60.9	66.7	69.6
<b>АҮНБ-д ББ-ний эзлэх хувь</b>	%	50.4	34.6	43.6	39.1	33.3	30.4

Эх үүсвэр: Ашигт малтмалын газар, 2012 он

Дэлхийн эдийн засаг, ялангуяа Азийн бүс нутгийн эдийн засгийн хурдацтай өсөлт, өөрчлөлт манай улсын эдийн засгийн гол тулгуур салбар болох эрдэс бүтээгдэхүүний зах зээл, үйлдвэрлэлд ихээхэн нөлөөлж байна.

**График №02: Уул уурхайн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь**




Манай орон уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дийлэнх хэсгийг БНХАУ-руу гаргаж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлогод:

- чулуун нүүрс 41.6%,
- зэсийн баяжмал 36.8%,
- төмрийн баяжмал 12.1%,
- цайрын баяжмал 6.4% эзэлдэг.

Эх үүсвэр: Ашигт малтмалын газар, 2012 он

**График № 03: Уул уурхайн салбараас улсын төсөвт оруулж байгаа татварын орлого**



**Төсвийн орлогын бүрдэлтэд:**

- Нүүрс - 55%,
- Зэс - 35%,
- Төмрийн хүдэр - 6%
- Эндээс дүгнэхэд, уул уурхайн бүтээгдэхүүний татварын орлого бүрдэлтийн 96 хувийг нүүрс, зэс болон төмрийн хүдэр эзэлж байна.

\* Эх үүсвэр: Ашигт малтмалын газар, 2012 он

2009 онд 14 уурхай, 2010 онд 12 уурхай, 2011 онд 19 уурхай ашиглалтанд оржээ. Эдгээр уурхайд 8700 ажлын байр шинээр бий болж, уул уурхайн салбарт нийт 50 мянган хүн ажиллаж байна.

2012 оны 6 дугаар сарын байдлаар 221.5 тн шороон орд, 2180.9 тн үндсэн ордын алтны орд, 231.4 мянган тн мөнгөний орд, 83.8 сая тн зэсийн хүдрийн орд, 1046.6 сая тн төмрийн хүдрийн орд, 18.5 сая тонн нүүрсний орд болон бусад ордуудын баталгаат нөөцтэй байна.

Уул уурхайн бүтээгдэхүүн бүрээр үйлдвэрлэл, хэрэглээ болон экспортын хэмжээг тодорхойлбол:

**а/. Төмрийн үйлдвэрлэл, хэрэглээ, экспорт:**

2012 оны байдлаар 726.5 сая тонн төмрийн хүдрийн нийт нөөцтэй байгаагаас 438,2 сая тонн баттай нөөц, 288,3 сая тонн таамаг нөөц болно. Манай төмрийн хүдрийн нөөц нь дэлхийн нөөцийн 2 хувийг эзэлдэг. Монгол улсын хэмжээгээр жилд 400 мянган тонн металл бэлдэц импортолж байна.

2010 онд 3.2 сая.тн, 2011 онд 5.7 сая.тн, 2012 оны эхний 8 сард 4.2 сая.тн төмрийн хүдэр, баяжмал экспортлосон. Манай нийт экспортын орлогын 12.1%-ийг төмрийн хүдэр, баяжмал эзэлж байна.

2017 -2020 онуудад төмрийн баяжмалын үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдүүлж 9 сая тонн-д хүргэх төлөвтэй байна. Хэрэв жилд дундажаар 10 сая тонн баяжмал экспортлоход 36 жилийн дотор манайх төмрийн хүдрийн нөөцгүй орон болох магадлалтай байна.

Манай төмрийн баяжмал нь олон улсын стандартыг хангахгүй байгаа зэргээс шалтгаалан төмрийн баяжмал бага үнээр борлогдож байна. Олон улсын металлын биржээр төмрийн бэлэн бүтээгдэхүүн, ган зэргийг арилжаалдаг. Төмрийн хүдэр, баяжмалын үнэ нь томоохон хэрэглэгч болон үйлдвэрлэгчдийн жишиг үнээр тогтдог. Төмрийн хүдэр, баяжмалын үнэ нь томоохон хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн “жишиг үнэ”-ээр (Platts'-ын үнэ) арилжаалдаг юм. Манай төмрийн баяжмал нь олон улсын стандартыг хангахгүй, эцсийн хэрэглэгчид худалдаж чадахгүй байна. Иймээс төмрийн баяжмал бага үнээр борлогдож байна.

Сүүлийн жилүүдэд Япон, Солонгос, ОХУ, БНХАУ-ын ган төмрийн үйлдвэрлэл нэмэгдсэнээр төмрийн хүдрийн эрэлт эрс өсч байна. Монгол улсын хувьд ч барилгын болон уул уурхайн салбарын эрчимтэй хөгжлийн дүнд дотоодын төмрийн хэрэгцээ өсөн нэмэгдэх хандлагатай байна. Төмрийг дэлхийн зах зээлд арилжаалах биржийн тогтолцоогүйгээс төмрийн хүдрийн нөөц, үйлдвэрлэлийн хүчин чадлыг үр ашиг багатай ашиглаж байна. Төмрийн хүдэр, баяжмалыг экспортлосноор төмөр замын ачаа эргэлт өсч, төмөр замын тээвэрлэлтийн ачааллыг нэмэгдүүлж байна.

#### **б/. Нүүрсний үйлдвэрлэл, хэрэглээ, экспорт:**

Манай улсын нүүрсний геологийн нийт нөөцийг 150 тэрбум тонн гэж тогтоосон. 18.5 тэрбум тонн нүүрсний нөөцийг урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын үр дүнгээр баттай зэрэглэлээр тодорхойлоод байна. Манай орон нүүрсний нөөцийн хэмжээгээр дэлхийд 9 дүгээр байранд орж байгаа буюу дэлхийн нийт нүүрсний нөөцийн 2%-ийг эзэлж байна.

БНХАУ-ын нүүрсний жилийн хэрэгцээ 3 тэрбум тонн. Тавантолгойн нүүрсний нийт нөөц 6 тэрбум тонн бөгөөд дээрх хэмжээгээр Хятад улс хэрэглэнэ гэвэл 2 жилийн дотор бүрэн ашиглах боломжтой. Өдгөө манайд 10 гаруй томоохон нүүрсний уурхайн ажиллаж, нүүрсээ экспортод гаргаж байна. 2011 онд 31 сая тонн нүүрс үйлдвэрлэж, 7 сая тонныг дотоодын зах зээлд ашигласан. 21 сая тонн нүүрс экспортлож, 2.2 тэрбум ам.долларын орлого олжээ. Ойрын 5-10 жилийн хугацаанд нүүрсний экспортыг 50-60 сая тоннд хүргэх боломж байна.Нүүрсний борлуулалттай холбоотой гарч болох сөрөг үзэгдэл нь манай уурхайнууд Хятадад дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн хямд үнээр борлуулж байна.

Нүүрсийг БНХАУ, Өмнөд Солонгос болон Япон зэрэг орнуудын гаргах тээвэрлэлт, тээврийн транзит зах зээлд асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байна. Нүүрсний чанарын ангилал, стандартыг боловсруулж батлуулах, нүүрсний боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, төмөр замын тээвэрлэлтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

#### **в/. Жоншны үйлдвэрлэл, хэрэглээ, экспортын түвшин**

Монгол уорны жоншны нөөц 20 сая тонн нөөцтэй. Нөөцөөрөө дэлхийд БНХАУ Мексик болон Өмнөд Африкийг дараа орж байна. Дэлхийн нийт жоншны экспортын 60 гаруй хувийг БНХАУ, 15 гаруй хувийг Монгол улс экспортлодог. “Монголросцветмет” ХХК-ийн Бор-өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, Өргөний уурхай, Монголчехсловакметалл хатарсан үйлдвэрийн Чулуут цагаан дэлийн уурхай, Бэрхийн уурхай нь хүдэр олборлож боловсруулж байна. Төрийн өмчит аж ахуйн нэгж “Монголросцветмент” ХХК-ийн үйлдвэрлэж байгаа жоншны баяжмалын чанар стандарт нь олон улсын стандартыг хангаж байна.Харин хувийн жонш үйлдвэрлэгчдийн баяжмалын чанарын түвшинг дээшлүүлэх, үнийн нэгдсэн бодлого баримтлах шаардлагатай байна.

## **г/. Зэсийн үйлдвэрлэл, хэрэглээ, экспортын түвшин**

Эрдэнэтийн зэсийн орд 1500 сая тонн, Оюутолгойн орд 2785 сая тонн зэсийн хүдрийн нөөцтэй. Эрдэнэт үйлдвэр жилд 519 мянган тонн зэсийн баяжмалыг экспортлож, 911.6 сая ам.долларын экспортын орлого олж байна. Энэ нь эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлогын 36.8 хувийг эзэлж байна. “Эрдмин” ХХК нь жилд 2.5 мян.тн катодын зэс үйлдвэрлэж, үүнээс 2.0 мянган.тн-ыг экспортлож, 0.5 мян.тн-оор зэс үйлдвэрлэж байна. Мөн “Эрдмин-II” үйлдвэр баригдаж шинээр ашиглалтанд орсноор манай орны цэвэр зэсийн үйлдвэрлэл 2-3 дахин нэмэгдэх төлөвтэй байна.

Манай орны зэсийн үнийн өөрчлөлтөөс зэсийн баяжмалаас олох валютын орлого, төсвийн орлогын бүрдэлт хэлбэлзэж ихээхэн эрсдэл учирч байна. Иймд зэсийн баяжмалын стандартыг бий болгох, худалдан авагчдын тоог олшруулах, үйлдвэрлэгч болон эцсийн хэрэглэгчидтэй шууд гэрээ хийх, ялангуяа чөлөөт зах зээлийн зарчмаар нээлттэй, ил тод арилжаалдаг арилжааны орчин үгүйлэгдэж байна.

### **1.2. Монгол улсын уул уурхайн салбарт тулгамдсан асуудал:**

Уул уурхайн бүтээгдэхүүн бүрээр үйлдвэрлэл, экспортын өнөөгийн байдлыг тодорхойлж байхад металл бүрд тодорхой хэмжээний сөрөг үзэгдлүүд тулгарч байсан. Уул уурхайн салбарын хувьд дараах нийтлэг тулгамдсан асуудалтай байна. Үүнд:

- Уул уурхайн уул уурхайн бүтээгдэхүүний худалдааг үйлдвэрлэгчид бие даан хийж байгаа ба борлуулагч, худалдан авагчдын хоорондын мэдээллийн сүлжээ хомс, харилцаа тогтоох үйл ажиллагаа өртөг өндөртэй байна.
- Монголын уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдан авах сонирхолтой байгууллагуудад мэдээлэл тэгш байдлаар хүрдэггүйгээс зах зээлийн өрсөлдөөний зарчмаар эрдэс бүтээгдэхүүний худалдааг хийгдэж чадахгүй байгаа нь манай орны эрдэс баялгийн үнэлэмжийг бууруулж байна.
- Зөвхөн борлуулагч болон худалдан авагч талын хооронд хийсэн гэрээний үндсэн дээр уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа хийгдэж, энэхүү гэрээнд тулгуурлан холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, төлбөрийг оногдуулж байна. Энэ нь эрдсийн үнэ, экспортын төлөвлөлтийг төдийлэн нээлттэй бус байх шалтгаан болж, түүнд тавигдах хяналтыг хүндрэлтэй болгож байна.
- Төсвийн орлогод гол үүрэг гүйцэтгэдэг зэс, нүүрс, алт болон төмрийн хүдрийн ханш, бүтээгдэхүүний үнийн уналтаас шалтгаалан эдийн засагт гарах эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх худалдааны арга хэрэгслэлүүдийг ашиглах шаардлагатай байна.
- Ашигт малтмалын шинэ ордуудын ээлж дарааллыг оновчтой тогтоож, ашиглалтанд оруулах салбарын бодлого баримтлаж, хүдэр баяжмалаар экспортлохоос илүүгээр эцсийн шатны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.
- Уул уурхайн салбарын орлого огцом буурвал дотоодын зах зээл дээрх үнэ, валютын ханш, Засгийн газрын орлого, гадаад валютын нөөцөд сөргөөр нөлөөлж улмаар бараа, бүтээгдэхүүний эрэлт буурахтай холбоотойгоор үйлдвэрлэл буурах сөрөг хандлага тулгарч байна.
- Өнөөгийн байдлаар манай улсад “Дарханы төмөрлөгийн үйлдвэр”, “Эрдэнэтийн Засвар механикийн үйлдвэр”, “Эрдмин”, “Хөх ган” зэрэг компанийг эс тооцвол металлургийн үйлдвэрлэл хөгжөөгүй байна.
- Манай улсад ажиллаж байгаа уул уурхайн үйлдвэрүүдэд техник технологийн шинэчлэл хийх замаар бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг олшруулах, илрүүлсэн эрдсийн нөөцийг хаягдал багатай боловсруулах, байгаль орчинд нөлөөлөл багатай технологи ашиглах зэрэг нь тулгамдсан асуудал болж байна.

### 1.3. Монгол улсад уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулах боломж

Уул уурхайн салбарт тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэхийн тулд уул уурхайн бүтээгдэхүүний бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Монгол улсын уул уурхайн салбарын хүдэрийг олборлох, баяжуулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүхийл үйл ажиллагаанд бэлтгэл нийлүүлэлттэй холбоотой зохион байгуулалттай нэгдсэн үйл ажиллагааг уул уурхайн бэлтгэлийн тогтолцоо гэж нэрлэдэг.<sup>1</sup>

Уул уурхайн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо нь эрдсийн бүтээгдэхүүний салбарыг үйлдвэрүүдтэй эдийн засгийн талаар холбон өгч байгаа худалдааны нэг хэлбэр юм. Дэлхийн олон орнуудын туршлагаас харахад зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд тулгарч байгаа асуудлуудыг “уул уурхайн бүтээгдэхүүний бирж” байгуулах замаар шийдвэрлэж байна.

Биржээр арилжих бүтээгдэхүүн нь дараах нөхцөл хангагдсан бүтээгдэхүүн байна.

- Хангалттай хэмжээний нөөцтэй байх;
- Идэвхтэй арилжаа хийдэг хэрэглэгчтэй байх;
- Стандартчлагдах боломжтой нэгэн төрөл, чанартай бүтээгдэхүүн байх;
- Тасралтгүй үйлдвэрлэл явуулдаг, мөн агуулахтай байх;

Манай орны хувьд хангалттай хэмжээний уул уурхайн бүтээгдэхүүний нөөцтэй, мөн томоохон хэрэглэгч улсууд болох БНХАУ, БНСУ, Япон болон бусад улсууд байна. Нүүрс, төмөр болон жоншны хувьд олон улсын стандартыг харьцангуй сайн хангагдсан бүтээгдэхүүн болно. Алт, зэс, мөнгө зэрэг өнгөт болон үнэт металлууд нь одоогийн байдлаар олон улсын стандартыг хангахгүй байна. Хэрэв агуулах, дэд бүтэц, хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлбэл Монгол улсад уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулагдах боломжтой болж байна. Үүнээс гадна барааны бирж нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байх шаардлагатай байна. Үүнд:

- Арилжаанд оролцогчдод нээлттэй, ил тод, хариуцлагатай байхаар сайн боловсруулагдсан хууль эрх зүйн орчинтой байх;
- Бүтээгдэхүүний чанар, зах зээлийн эрэлт хэрэгцээ, нийлүүлэлттэй уялдсан үнийн тогтолцоог бүрдүүлсэн арилжаа явагддаг байх;
- Орчин үеийн шаардлага стандартыг хангасан агуулах, санхүүгийн байгууллага, лаборатори болон тээвэр логистикийн сүлжээтэй байх;
- Арилжаанд оролцогчид үнэн зөв, шуурхай мэдээлэл авах, арилжаа хийх боломжоор хангагдсан техник, технологи, програмчлалын сүлжээтэй байх;
- Арилжаанд оролцогч брокерууд болон оролцогчид үнэнч шударга, ёс зүйтэй, өргөн мэдлэгтэй, мэргэшсэн чадварлаг байх;
- Шинэ дэвшилтэт технологийг биржийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх;

---

<sup>1</sup> - Л.Базаррагчаа, “Түүхий эд бэлтгэлийн эдийн засаг”, 1974 он, х-4

## Хоёр. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн олон улсын туршлага

### 2.1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үүсэл, хөгжил

Аливаа бизнесийн үйл ажиллагаа, арилжаанд аль болох бага зардалтайгаар оролцох нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой. Худалдан авагч буюу эцсийн хэрэглэгч нь биржээр дамжуулан бараа, бүтээгдэхүүнийг худалдан авалт хийдэг. Энэ системийг “pull system” буюу худалдан авалтын систем гэж нэрлэдэг. Энэ системийг олон улсад зуучлагчтай буюу зуучлагчгүй гэж ангилдаг. Зуучлагчтэй арилжааны зохион байгуулалттай хэлбэрийг бирж, зохион байгуулалтгүй арилжааны хэлбэр нь ченжийн арилжаа гэж нэрлэдэг байна.



Үйлдвэрлэгч болон худалдагч бүтээгдэхүүнээ борлуулах, хамтран ажиллахыг хүсч байгаа аж ахуйн нэгжийг олох, худалдан авах үнийг санал болгох, гэрээг байгуулах яриа хэлэлцээг зохион байгуулах зэрэг шаардлага тулгардаг. Бирж буюу төвлөрсөн зохион байгуулалттай арилжааны газар байхгүй тохиолдолд эдгээр ажилд их зардал гардаг.

Зохион байгуулалтгүй арилжаа хийж байгаа үед ихээхэн хэмжээний зардал гарахын зэрэгцээ хугацаа алдах, томилолтоор удаа дараа явах, барааны үзэсгэлэн, олон улсын хурал, зөвөлгөөнд байнга оролцох, бизнесийн ажилд аз турших явдал гаргах, зарим тохиолдолд алдагдал хүлээх зэрэг сөрөг үзэгдлүүд бий болдог.

Өнөөгийн бараа, бүтээгдэхүүний бирж жинхэнэ утгаараа XIV-XV зууны үед Европт байгуулагдсан гэж үздэг. Бирж байгуулагдсанаасаа хойш түүхийн энэ урт хугацааны туршид үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, арилжааны арга хэрэгсэл нь улам боловсронгуй болж, ихээхэн туршлага хуримтлуулан зах зээлийн зохицуулалтын чухал хэрэгсэл болтлоо хөгжиж иржээ.

Биржийг байгуулах, үйл ажиллагаагаа зохицуулах асуудалд улс орон болгон өөрийн орны өвөрмөц онцлогыг харгалзан хандаж иржээ. Биржийн хөгжлийн тодорхой үе шатуудад биржээр арилжаалах байгаа бараа, бүтээгдэхүүний нэр төрөл, чанарын стандартад нилээд өөрчлөлт орсон.

Европ болон Хойд Америк болон томоохон эдийн засагтай, зах зээлийн багтаамж ихтэй орнуудын хувьд бэлэн бараа, бүтээгдэхүүний төрөлжсөн биржийг ихэвчлэн хөгжүүлсэн. Өнөөдөр дэлхийн улс орнуудад байгуулагдсан хөдөө аж ахуйн болон уул уурхайн бараа, бүтээгдэхүүний биржүүдийн 50 орчим хувь нь АНУ-д, үлдсэн хувь нь Европ тивийн болон Азийн орнуудад үйл ажиллагаа явуулж байна. Барааны биржийн 46%-ийг хөдөө аж ахуйн бирж, 27%-ийг уул уурхайн бирж, 27%-ийг эрчим хүчний биржээр тус тус арилжаалж байна.

Хүснэгт 4: Дэлхийн барааны биржүүдийн гэрээний тоо

Он	2000	2002	2004	2007	2010
-Уул уурхай	112	127	172	186	197
-Эрчим хүч	155	209	243	256	261
-Хөдөө аж ахуйн	186	147	312	388	412

Эх үүсвэр: UNCTAD –ын хийсэн барааны биржийн судалгаа

**Хүснэгт 5: Өндөр хөгжилтэй орнуудад үйл ажиллагаа явуулж байгаа бараа, бүтээгдэхүүний фьючерын барааны биржүүд**

Бирж	Улс	Фьючерын бараа	Байгуулагдсан он	Арилжааны хэмжээ
CME Group	АНУ	✓ Хөдөө аж ахуй ✓ Эрчим хүч ✓ Эрдсийн бараа	1872	674,970,671
London Metal Exchange	Англи	✓ Эрдсийн бараа	1877	104,157,840
Tokyo Commodity Exchange	Япон (TOCOM)	✓ Хөдөө аж ахуй ✓ Эрчим хүч ✓ Эрдсийн бараа	1951	27,564,721
Australian Securities Exchange	Австрали	✓ Бараа, хувьцаа	1960	230,293
Korea Exchange	Өмнөд Солонгос	✓ Хөдөө аж ахуй ✓ Эрдсийн бараа	2008	NA

Эх үүсвэр: Барааны биржүүд, WFE

1990-2000 онуудад биржийн хөгжлийн түүхэнд шинэ үе эхэлсэн. Япон, Өмнөд Солонгос, Хятад, Энэтхэг, Иран, Өмнөд Африк болон Бразил зэрэг орнуудад бараа, түүхий эдийн биржүүд нь үйл ажиллагаагаа амжилттай явуулж бэлэн бүтээгдэхүүний болон форвард гэрээ хэлцлийн тоо, арилжааны эргэлтийн хэмжээгээр АНУ болон Европын биржүүдтэй өрсөлдөх болсон.

**Хүснэгт 6: Хөгжиж байгаа орнуудын фьючерын барааны биржүүд**


Бирж	Улс	Барааны Бирж	Байгуулагдсан он	Арилжааны хэмжээ
Shanghai Futures Exchange	Хятад	✓ Эрдсийн бүтээгдэхүүн ✓ Эрчим хүч, ✓ Хөдөө аж ахуй	19 98	621,898,215
Zhengzhou Commodity Exchange	Хятад	Хөдөө аж ахуй	19 90	495,904,984
Dalian Commodity Exchange	Хятад	Хөдөө аж ахуй	19 93	403,167,751
Multi Commodity Exchange of India	Энэтхэг	✓ Эрдсийн бүтээгдэхүүн ✓ Хөдөө аж ахуй	20 03	197,206,801
Johannesburg SE	Өмнөд Африк	✓ Эрдсийн бүтээгдэхүүн ✓ Эрчим хүч, ✓ Хөдөө аж ахуй	-	1,834,924
Turkish Derivatives Exchange	Турк	✓ Эрдсийн бүтээгдэхүүн ✓ Хөдөө аж ахуй	2005	147,492
Hong Kong Exchanges	Хонконг	Эрдсийн бүтээгдэхүүн	1976	5,642
Dubai Gold & Commodities Exchange	UAE	✓ Эрдсийн бүтээгдэхүүн ✓ Эрчим хүч,	20 05	NA
Pakistan Mercantile Exchange	Пакистан	✓ Эрдсийн бүтээгдэхүүн ✓ Эрчим хүч ✓ Хөдөө аж ахуй	2007	NA
Ukrainian Futures Exchange	Украин	✓ Эрдсийн бүтээгдэхүүн ✓ Эрчим хүч ✓ Хөдөө аж ахуй	20 10	NA



Хөгжиж байгаа орны хувьд бараа бүтээгдэхүүний спот буюу бэлэн бүтээгдэхүүний шууд арилжааны бирж байгуулах сонирхолтой бол өндөр хөгжилтэй оронд гэрээний биржүүдийг байгуулах сонирхол ихтэй байдаг. Эрсдлээ удирдах зорилготой байдаг. Үүний тулд томоохон худалдаачид, томоохон хэрэглэгчид рүү онилсон эсвэл биржийн гадуурх оролцогчид болох жижиглэн худалдаалагчид болоод жижиг бизнес эрхлэгчдийг татахад чиглэнэ. Бирж дээр үнэ тогтсон үед биржийн гадуурх арилжаа нь мөн биржийн үнийг жишиг болгодог систем бүрддэг.

Дэлхий дээр үйл ажиллагаа явуулдаг Металлын 23 бирж байдаг.

- ⊕ бүх биржээр алт;
- ⊕ цагаан алт 8 биржээр;
- ⊕ мөнгө 13 биржээр;
- ⊕ Газрын ховор металл 5 биржээр;
- ⊕ Зэс 12 биржээр;
- ⊕ Ган, хөнгөн цагаан 8 биржээр, хар, цагаан тугалга 6 биржээр тус тус арилжаалж байна.



## 2.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн төрөл

**Бирж гэдэг** нь дүрэм, журамд үндэслэн худалдагч, худалдан авагчдын хооронд эрдсийн бүтээгдэхүүн болон бүтээгдэхүүний стандарт гэрээнүүдийг арилжаалах зах зээлийг хэлнэ. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж нь аливаа улс орнуудын бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгч, худалдаачид болон хэрэглэгчдэд аль алинд харилцан үр ашигтай, хэрэгцээтэй байдаг байна.

Барааны биржийн гол зорилго нь дараах чиглэлтэй.

1. үнийг ил тод байлгаж, үнийг тогтоох;
2. бодит мэдээллээр хангах
3. худалдааны зардалыг багасгах;

Бирж байгуулах тохиолдолд уул уурхайн биржийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуултууд тулгарна. Үүнд:

- Биржийн зорилго, зарчим ямар байх;
- Биржийн үйлчилгээний төрөл юу байх;
- Биржийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хэлбэр ямар байх;
- Биржийн өмчлөлийн статус хэнийх байх;
- Биржийн үйл ажиллагаанд төрийн оролцооны үүрэг ямар түвшинд байх;
- Биржийн гишүүнчлэлийн төрөлд хэн хамрагдах боломжтой эсэх;
- Биржийн арилжааны төрөл хэрхэн ангилагдах;
- Биржээр арилжаалах бүтээгдэхүүн, түүний чанар, чанарын стандарт;
- Биржийн орлогын эх үүсвэр юу байх;

Бүтээгдэхүүний бирж нь барааны нэр төрөл, зорилго газарзүйн байршил, арилжааны хэлбэр, арилжаанд оролцогчдын байдал, өмчийн хэлбэр болон төрийн оролцооны түвшингээс хамааруулж төрөл бүрээр ангилж үзэж болно.

1. **Салбараар нь:** Салбараар нь ангилвал уул уурхайн бирж (алт, зэс, ховор, үнэт металл), эрчим хүч (нефть, нефтийн бүтээгдэхүүн, байгалийн хий), хөдөө аж ахуйн түүхий эдийн бирж гэж ангилдаг.
2. **Байршилаар нь:** Хөдөө аж ахуйн биржийг газар зүйн байршил болон хамтын ажиллагааны цар хүрээнээс хамааруулан орон нутгийн, бүс нутгийн болон олон улсын шинж чанартай гэж ангилдаг.

3. **Арилжааны хэлбэрээр нь:** Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг арилжааны хэлбэрээр нь бэлэн бүтээгдэхүүний болон гэрээний арилжаа гэж ангилдаг. Гэрээний арилжааг форвард, опцион болон фьючерсийн гэж ангилж байна.
4. **Арилжаанд оролцогчдын байдлаар нь:** Арилжаанд оролцогчдын байдлаар гишүүнчлэлтэй, гишүүнчлэлгүй гэхээс гадна нээлттэй, хаалттай гэж ангилдаг.
5. **Өмчийн хэлбэрээр нь:** Биржийг байгуулах хөрөнгө, хувь оролцоогоор нь төрийн өмчийн оролцоотой, хувийн хэвшлийн оролцоотой, төр болон хувийн хэвшлийн хамтын өмчийн оролцоотой гэж ангилж үзэж болдог байна.

### Бирж байгуулахад болон байгуулсны дараагаар үүсч болох эрсдлүүд

Бирж байгуулахад дараах эрсдлүүд тулгардаг. Үүнд:

- **Гүйцэтгэлийн эрсдэл:** Агуулах үйлчилгээ, ангилан ялгалт, худалдаа, арилжаа зохион байгуулах, Төлбөр тооцоо, хэлэлцээрийг зохион байгуулахад эрсдэл учирдаг.
- **Гэрээний эрсдэл:** Гишүүд нь биржийн өмнө хариуцлага хүлээнэ.
- **Суурь эрсдэл:** Хэджинг хийгдэх явц дахь суурийн өөрчлөлтөөс хамаардаг. Суурь эрсдэл нь дотроо эрдсийн бүтээгдэхүүний чанар, гэрээний нөхцлүүд, нийлүүлэлтийн байршил болон хугацаанаас хамаардаг.
- **Үнийн эрсдэл:** Зах зээлд оролцогчдод орлого олох боломжтой хугацаанд харгалзах эрдсийн бүтээгдэхүүний үнийн стандартын тухай ойлголт хамаардаг. Үнийн эрсдэлд хэджин, манифуляц болон спекуляц зэрэг ойлголтууд хамаарна.
- **Үйлдвэрлэлийн эрсдэл:** Байгалийн гэнэтийн өөрчлөлт тухайлбал ган, зуд эсвэл үйлдвэрлэлийн осол зэргээс шалтгаалан төлөвлөсөн хугацаанд эрдсийн бүтээгдэхүүнээ гэрээний дагуу нийлүүлж чадахгүй болсонтой холбоотой эрсдлийг хамааруулж үздэг.
- **Засгийн газрын оролцооны эрсдэл:** Засгийн газар нь биржийн үйл ажиллагаанд хязгаарлагдмал байдлаар оролцох нь зүйтэй байгааг олон улсын туршлага байна. Хөгжиж байгаа улс орнуудын хувьд Засгийн газар нь биржийн эрхзүйн орчинг бүрдүүлэх, дэд бүтцийг сайжруулах, биржийн арилжаанд гишүүн хэлбэрээр оролцож, арилжааг эрчимжүүлэх зэргээр оролцож болдог.

### Хүснэгт 7: Биржийн дэд бүтэц

Систем	Дэд бүтэц	Дүрэм, журам	Оролцогч
Үйл ажиллагаа: - Агуулахын үйл жиллагаа - Дээж авах - Жинлэх - Ангилах - Хүлээн авах - Төлбөр тооцоо хийх - Мэдээлэл - Арбитр	Биржийн тал: - Агуулахын аж ахуйн - ICT систем	- Эрхзүйн орчин - Арбитрийн ажиллагаа - Гишүүнчлэл - Брокер - Мэргэжлийн холбоо - Удирдлага	- Барилга байгууламж - Биржийн орон тоо, ажилагсад - Зөвлөл - Гишүүд - Хэрэглэгчид - Нийтийн мэдээллийн сан

## Гурав. Монгол улсад байгуулах уул уурхайн бүтээгдэхүүний загвар

Уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулагдснаар олон давуу үр ашиг бий болно. Үүний нэг асуудал бол чанар. Бирж дээр чанараас хамаарч үнэ тогтоно. Өндөр чанартай эрдсийн бүтээгдэхүүн өндөр үнэтэй байх боломжтой болно. Энэ нь уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэж байгаа болон сонирхолтой жижиг дунд бизнес эрхлэгчдийг татах боломжийг бүрдүүлдэг.

Уул уурхайн олборлон боловсруулах үйлдвэрийн салбарт ажиллаж байгаа гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, үйлдвэрүүдийн өргөтгөл, шинэчлэлт, шинэ төслүүдийн ойрын хугацаанд хэрэгжих боломж, шинэ хүчин чадлыг харгалзан үзэж шинээр үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл, чиглэлийг тодорхойлсон болно. Үүнд:

Эрдсийн төрөл	Одоо үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн	Агуулга	Одоогийн үйлдвэрлэл	Шинээр үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл	Худалдан авагч орнуудын чанарын агуулга
<b>1.Төмөр</b>	- Төмөр бэлдэц - Төмрийн хүдэр - Төмрийн баяжмал	40-55%  62-65%	50.0 мян.тн  1.6 сая.тн  4.0 сая.тн	✓ Арматурын төмөр ✓ Ангижруулсан төмөр ✓ Шингэн ширэм ✓ Хуудсан төмөр ✓ Рельс, балка ✓ Ган хоолой ✓ ХАА, УУ-н машины эд, анги	80-95%
<b>2.Нүүрс</b>	Нийт, үүнээс: - Эрчим хүчний нүүрс - Коксжих түүхий нүүрс - Угааж баяжуулсан нүүрс		30.9 сая.тн	✓ Цахилгаан эрчим хүч ✓ Коксжих нүүрс ✓ Угааж баяжуулсан нүүрс ✓ Хагас кокс ✓ Кокс ✓ Нүүрсний хий ✓ Шингэн түлш	
<b>3.Жонш</b>	- Жоншны хүдэр - Жоншны баяжмал ✓ Флотацын ✓ Бүхэллэг	30-40%  95-97% 75, 85%	500 мян.тн  403 мян.тн  152 мян.тн 251 мян.тн	✓ Өндөр агуулгатай флотацын баяжмал ✓ Фторт ус төрөгчийн нэгдэл HF ✓ Керолит ✓ Хөнгөн цагааны исэл ✓ Шил ✓ Хөргөгчийн шингэн	95-97%
<b>4.Зэс</b>	✓ Хүдэр ✓ Баяжмал ✓ Цэвэр зэс	0.5-1.2% 24-30% 99.99%	26 сая.тн 550 мян.тн 2.4 мян.тн	✓ Хайлуулсан ✓ Цэвэр зэс ✓ Зэс утас ✓ Зэс хоолой ✓ Зэс гуурс ✓ Зэс ороомог ✓ Зэс эдлэл	99% 99.99%

Биржийн арилжаа нь олон улсын стандартын шаардлагад нийцсэн, дэлхийн зах зээлд өрсөлдөх бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортын чадавхийг нэмэгдүүлэх, нэр төрлийг олшруулах буюу импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж ажиллах нь биржийн нэг үүрэг байдаг.

Биржийг байгуулахдаа гадаадын улс орнуудын амжилттай явуулж байгаа биржийн загварыг шууд хуулбарлаж үйл ажиллагаа явуулбал амжилтад хүрдэггүй байна. Өөрийн орны онцлогт тулгуурлан биржийг байгуулбал зохистой байдаг. Монгол улсад уул уурхайн бүтээгдэхүүний биржийг байгуулахдаа олон улсын туршлагатай харьцуулсны үндсэн дээр дараах зарим саналыг дэвшүүлж байна. Энэ санал бол эцсийнх биш, судалгааны шатанд явж байгаа болно.

	<b>Биржийн үйл ажиллагаа</b>	<b>Санал</b>
1	биржийн зорилго, зарчим	<p>Манай орны хувьд уул уурхайн бүтээгдэхүүнд боловсруулалт хийж, өртөг шингээж, экспортлодог үйлдвэрлэлийг хөгжүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнээр чөлөөтэй, ил тод арилжаалах зэрэг тулгамдсан асуудал тулгарч байна.</p> <p>Энэ асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулж, тогтсон дэг журмын дагуу чөлөөтэй ил тодоор арилжаа хийх боломжийг бүрдүүлнэ. <b>Бирж нь хараат бус, бие даасан, нээлттэй, ил тод байх зарчмыг</b> баримтлан үйл ажиллагаа явуулна.</p>
2	биржийн үйлчилгээний төрөл	<p>Биржийн оролцогчид дараах үйлчилгээ үзүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зах зээлийн бодит мэдээллээр хангах;</li> <li>- Спот болон фьючерийн үнийг тогтоох;</li> <li>- Үнийн эрсдлээс хамгаалах боломжоор хангах зорилгоор хэджин худалдаа зохион байгуулах;</li> <li>- Бүтээгдэхүүний чанарын стандартыг батлах;</li> <li>- Гэрээний загварыг боловсруулж батлах;</li> <li>- Төлбөр тооцоо, агуулах, тээвэр, лабораториудад итгэмжлэх олгох;</li> <li>- Мэргэжлийн сургалтыг зохион байгуулах, гадаад болон дотоодод туршлага солилцуулах;</li> </ul>
3	биржийн өмчлөлийн статус	<p>Бирж нь дараах өмчлөлийн статустай байдаг байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн 100%-ийн өмчтэй</li> <li>- Хувийн 100%-ийн өмчтэй</li> <li>- Төр болон хувийн хамтарсан өмчтэй</li> </ul> <p>Өмчлөлийн асуудалд үндэсний хөрөнгө оруулалттай болон гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай хэлбэрүүд байдаг. Манай орны хувьд биржийг төрийн өмч давамгайлсан төрийн, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн хамтарсан оролцоотой хувьцаат компани хэлбэрээр байгуулах саналтай байна. Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд бирж байгуулахад оролцох боломжгүй бөгөөд үндэсний брокерийн компаниудаар дамжуулан арилжаанд оролцох боломжтой.</p>
4	Биржийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хэлбэр	<p>Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь биржийг байгуулах үүсгэн байгуулагч болж, тус үүсгэн байгуулагчийн санаачилгаар Засгийн газар байгуулж, Санхүүгийн зохицуулах хорооны хяналтад дор бирж үйл ажиллагаа явуулна.</p>
5	Биржийн үйл ажиллагаанд төрийн оролцооны үүрэг	<p>Бирж нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хуулийн дагуу арилжааг зохион байгуулдаг зуучлагч байгуулагч бөгөөд төр биржийн үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд зах зээлийн үнэд өөрчлөлт гарч, зах зээлийн гажуудлыг үүсгэж, биржийг дампууруулах үндэс болдог.</p> <p>Төрийн биржийн үйл ажиллагаанд оролцох боломж нь эрх зүйн орчинг бүрдүүлэх, биржийн дэд бүтцийг байгуулах, мэргэжлийн түвшингийн мэргэжилтэнгүүдийг бэлтгэх зэрэг болно.</p>

6	Биржийн гишүүнчлэлийн төрөл, хэлбэр	Биржийн гишүүнийг дараах байдлаар ангилна. <ul style="list-style-type: none"> <li>Арилжаа болон төлбөр тооцоо хийх эрхтэй арилжааны брокер буюу бүрэн гишүүнчлэлтэй гишүүн</li> <li>Зөвхөн төлбөр тооцоо хийх эрхтэй бүрэн гишүүнчлэлтэй гишүүн</li> <li>Зөвхөн арилжаанд оролцох эрхтэй арилжааны туслах брокер буюу бүрэн бус гишүүнчлэлтэй гишүүн</li> </ul>
7	Биржийн арилжааны төрөл	Биржийн арилжаа нь дуудлага болон цахим худалдаа хэлбэрээр явагдах ба дараахь төрлийн арилжаа явагдана: <ul style="list-style-type: none"> <li>барааны биет арилжаа;</li> <li>форвардын гэрээний арилжаа;</li> <li>опционы гэрээний арилжаа</li> </ul> Шинээр байгуулах биржийн хувьд эхний ээлжинд биет арилжааг дуудлага худалдаа, цахим хэлбэрийг ашиглана.
8	Биржээр арилжаалах бүтээгдэхүүн	Манай уул уурхайн биржээр эхний ээлжинд нүүрс, төмөр, жоншны хүдэр, баяжмалыг арилжаална. Дараагийн ээлжинд гянт болд, зэс, молибден, цайр зэрэг бүтээгдэхүүнийг томоохон биржүүдийн бүтээгдэхүүний стандартын түвшинд хүргэснээр арилжаалахаар тооцоолсон.
9	Биржийн арилжаанд оролцогчид, тэдгээрт тавих шаардлага	Биржийн арилжаанд оролцогч нь брокер, биржийн арилжаанд зах зээлд оролцогч нь тээвэр зуучийн байгууллага, арилжааны банк, агуулах, ангилан ялгах төв, лаборатори болон хяналтын байгууллагууд юм.
10	биржийн орлогын эх үүсвэр	Биржийн орлогын дараах эх үүсвэртэй байна. <ul style="list-style-type: none"> <li>биржийн суудлын төлбөр;</li> <li>гишүүнчлэлийн татвар</li> <li>арилжаанд оролцогчид үзүүлсэн үйлчилгээний хураамж;</li> <li>хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаас олсон бусад орлого.</li> </ul>

Манай улсын эрдсийн бүтээгдэхүүний олборлолт, үйлдвэрлэлийн өнөөгийн түвшин, цаашдын хандлагыг харгалзан биржээр арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээ, арилжаалах үе шатыг тодорхойлов. Үүнд:

**Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ  
(Арилжаалах үе шат)**

№	Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Үйлдвэрлэх, хүчин чадал (2011)	Арилжаалах боломжит үе шат		
				I ээлж (2012-2014)	II ээлж (2015-2016)	III ээлж (2017-2020)
1	Нүүрс	сая.тн	30.9	12.0	24.0	65.0
2	Төмрийн хүдэр, Баяжмал	сая.тн	5.7	5.7	5.7	9.0
3	Жонш					
	- Баяжмал	мян.тн	152	22.0	152.0	200.0
	- бүхэллэг	мян.тн	251	150.0	200.0	300.0
4	Гянт болд					
	- баяжмал	тн	163.2	-	60.0	163.2
5	Зэсийн баяжмал	мян.тн	550	-	550.0	1000.0

6	Катодын зэс	мян.тн	2.5	-	2.5	10.0
7	Молбидены баяжмал	тн	3800	-	1500.0	3800
8	Цайрын баяжмал	мян.тн	100	-	50.0	100

Эх үүсвэр: Экспортлогчдын холбоо, 2012 он

Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, үе шат болон арилжаалах бүтээгдэхүүний тоо хэмжээний тооцооллын судалгааг тусгасан. Судалгааны ажлын үр дүнд уул уурхайн бүтээгдэхүүний агуулахууд, ложистикийн төвүүдийг дараах байдлаар сонгож, байршлыг тогтоов. Үүнд:

**Уул уурхайн бүтээгдэхүүний агуулахууд, ложистикийн төвүүдийн сонголт, байршил**

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Агуулахууд		Логистикийн төвүүд	
		Байршил	Хүчин чадал**	Байршил	Хүчин чадал**
1	Нүүрс	Тавантолгой	5.0 сая.тн	Хилийн боомт	10.0 сая.тн
2	Төмөр - Баяжмал	Дархан, Ерөөгол	2.0 сая.тн 1.0 сая тн	Хувалбар-1: Ерөө Хувилбар-2: Дархан	1.0 сая.тн 2.0 сая тн
3	Жонш - Жоншны баяжмал - Бүхэллэг жонш	Бор-өндөр, Говьсүмбэр	50.0 мян.тн 100.0 мян.тн	Говьсүмбэр	150.0 мян.тн
4	Зэсийн баяжмал	Эрдэнэт, Сайншанд, Оюутолгой	40.0 мян.тн 90.0 мян.тн* 50.0 мян.тн	Сайншанд	100.0 мян.тн
5	Катодын зэс	Эрдэнэт, Оюутолгой	3.0 мян.тн 10 мян.тн	Сайншандад	20.0 мян.тн
6	Молибдены баяжмал	Эрдэнэт, Оюутолгой	3.0 мян.тн 10.0 мян.тн	Сайншанд	13.0 мян.тн

Эх үүсвэр: Экспортлогчдын холбоо, 2012 он

\*Сайншандад АҮП байгуулагдсанаар

\*\*Төлөвлөж байгаа хүчин чадал

**Дөрөв. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж байгуулснаар уул уурхайн салбарт гарах үр өгөөж**

Бирж нь үйлдвэрлэгч хэрэглэгчийн ажлын уялдаа холбоо, тэдгээрийн урт хугацааны тогтвортой харилцааг хангана. Үүнээс гадна дараах давуу талыг бий болгож байна. Үүнд:

- Бирж нь аль нэг салбарын бус тухайн улс орны эрх ашгийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.
- Бие даасан, төрөөс үл хамааран өөрөө өөрийгөө зохицуулдаг бирж нь зах зээлийн зарчмаар ажиллаж үнийн тогтвортой байдлыг хангана.
- Биржийн арилжаанд оролцогчдын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, мэргэжлийн худалдаачдыг арилжаанд өргөнөөр оролцуулснаар худалдааны чанарын түвшинд дэвшил гардаг.
- Биржийн арилжаанд оролцогчдод тодорхой дэг журам тогтоож хэрэгжүүлдэг бөгөөд тухайн улс орны худалдаа арилжааны практикт эерэг сайнаар нөлөөлдөг.
- Арилжааны журам, түүний хэрэгжилт нь нийт оролцогчдод ил тод байдаг Тэдэнд адил тэнцүү нөхцөл байдал бий болгож чөлөөт өрсөлдөөнийг хөхүүлэн дэмждэг.
- Барааны чанарыг тогтоох, үйлдвэрлэгч, борлуулагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, улмаар мэргэшүүлэх энгийн үр дүнтэй механизмыг бүрдүүлдэг.

- Үйлдвэрлэлийн томоохон бүс, төвүүдийг түшиглэн биржийн салбар, агуулах, тээвэр, ложистик, санхүүгийн байгууллагууд байрладаг бөгөөд бараа, бүтээгдэхүүний худалдагч, худалдан авагч нар бие биенээ хурдан олоход давуу талтай.
- Үйл ажиллагааны нэмэлт зардал багасч бараа, бүтээгдэхүүний нэгжийн зардал буурах боломж бүрддэг.
- Биржийн арилжаанд оролцогчдын хувьд биржийн мэдээ, мэдээлэл, гэрээ хэлцэлээ үндэслэн бизнесээ төлөвлөх, хэрэгцээ шаардлагаа бодитоор тооцоолох, бизнесээ өргөтгөх зэрэг боломж бий болдог.
- Худалдагч, худалдан авагч нар өөр хоорондоо байнга харилцан, хамтран ажиллаж байдаг. Энэ нь тухайн бүтээгдэхүүний ирээдүйн эрэлт, нийлүүлэлтийн төлөвийн талаар өөрсдийн санаа, мэдээ мэдээллийг чөлөөтэй хуваалцах боломжийг олгодог. Үүний үр дүнд бараа бүтээгдэхүүн тус бүрээр харьцангуй үнэн бодит мэдээлэл дээр тулгуурласан, гэнэтийн өөрчлөлтөнд бага өртөхүйц үнэ тогтдог.
- Санхүүгийн салбарт ахиц гарч, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид уул уурхайн салбарт хөрөнгө оруулах боломж бүрдэнэ;
- Үйлдвэрлэгч, хэрэглэгчдэд зах зээлийн үнээр арилжаа хийх боломж бүрдэх, үнийн эрсдлийг удирдах, биржийн оролцогчдын орлого тогтворжих, бараа, бүтээгдэхүүний чанар сайжрах, нийлүүлэлтийн тогтолцоонд дэвшил бий болох зэрэг ач холбогдолтой.

#### ***Биржийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:***

- ✓ Бэлэн бус төлбөр тооцоо нэмэгдэнэ
- ✓ Мөнгөний эргэлт нэмэгдэнэ
- ✓ Татварын хяналт сайжирна
- ✓ Дотоодын үйлдвэрлэл өснө
- ✓ Ажлын байр нэмэгдэнэ
- ✓ Тээвэрлэлт төвлөрч, бүтээгдэхүүний даатгалын зах зээл хөгжинө

#### ***Үйлдвэрлэгч, нийлүүлэгч болон хэрэглэгчдийн хувьд дараах нөлөө үзүүлнэ:***

- ✓ Бүтээгдэхүүний чанар сайжирч стандарт (брэнд)-тэй болно
- ✓ Зах зээлийн үнээр арилжаа хийнэ
- ✓ Үнийн эрсдлийг удирдах боломжтой
- ✓ Үйлдвэрлэгчид болон арилжаанд оролцогчдын орлого нэмэгдэнэ
- ✓ Даатгагдсан тээвэрлэлт хийгдэнэ

Нэгтгэж үзвэл макро эдийн засгийн түвшинд бэлэн бус төлбөр тооцоо нэмэгдэх, мөнгөний эргэлт сайжрах, татварын хяналт сайжрах, дотоодын үйлдвэрлэл өсөх, ажлын байр нэмэгдэх, агуулахын аж ахуй, стандартын тээвэр болон даатгалын зах зээл хөгжих, үнийн түвшин тогтворжих боломж бий болно. Үүнээс гадна санхүүгийн салбарт ахиц гарч арилжааны банкууд биржийн платформд оролцсоноор шинээр харилцах данс, карт эзэмшигчид нэмэгдэх, хөрөнгө оруулалт нэмэгдэж, арилжааны банк эрсдэл багатай хөрөнгө оруулалтыг биржийн арилжаагаар дамжуулан хийх боломж бүрдэх давуу талтай байдаг.

#### ***Дүгнэлт***

Уул уурхайн салбарт тулгарч байгаа асуудлууд, гарч байгаа сөрөг үзэгдлүүдийг шийдвэрлэхийн тулд улс орнууд эрсдийн бүтээгдэхүүний бирж байгуулж байна. Биржийг байгуулахдаа гадаадын улс орнуудын амжилттай явуулж байгаа биржийн загварыг шууд хуулбарлаж үйл ажиллагаа явуулбал амжилтад хүрдэггүй байна. Өөрийн орны онцлогт тулгуурлан биржийг байгуулбал зохистой байдаг.

Бирж байгуулагдснаар макро болон микро түвшинд олон талын давуу талууд бий болдог. Тухайлбал, оролцогчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, оролцогчдыг татах, үнийн тэгш бус байдлыг арилгах, биржийн оролцогчдын тоог ихэсгэх, тэдний ашиг, хонжоог нэмэгдүүлэх, үнийн өөрчлөлтийн эрсдлийг удирдах зэрэг олон боломжууд бий болно. Ийм учраас шинээр бирж

байгуулахдаа аль болох өөрийн орны онцлог болон эдийн засгийн тогтолцоо, хөгжлийн түвшинд тохируулж зохион байгуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрээд байна.

**Ашигласан ном, хэвлэл:**

- [1] UNCTAD, “Биржийн хөгжил” судалгааны тайлан, 2008 он, х-8
- [2] UNCTAD, судалгааны тайлан, 2008 он, х – 18
- [3] Б.Жадамба, “Бараа, түүхий эдийн биржийн тухай” ном, 2009 он, х-11
- [4] Б.Норжваанчиг, “Эдийн засгийн сургаалийн түүх”, 2001 он, х-111
- [5] Л.Базаррагчаа, “Түүхий эд бэлтгэлийн эдийн засаг”, 1974 он, х-4
- [6] Брайн, С.Фишир, Б.Түвшинтөгс ... “Оюутолгой зэсийн ордын ашиглалт”, УБ, 2011 он
- [7] Монгол улсын уул уурхайн салбараас нийгэм эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл, байгаль орчин, АМГ-ын УУСХ-ийн дарга, Ц.Даваацэрэн, 2011.12.08
- [8] Commodity Prices and Price Forecast in Dollars Commodity Price Forecast Update Released: January 17, 2012
- [9] LME Official Prices (US\$/tonne) for 15 Mar 2012 (Data >1 day old), [www.lme.com](http://www.lme.com)
- [10] Вэб хуудас: [www.nso.mn](http://www.nso.mn), [www.erdenetmc.mn](http://www.erdenetmc.mn), [www.lme.co.uk](http://www.lme.co.uk) , [www.unctad.org](http://www.unctad.org) ... etc